



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/537

Чингис хот

Сургалтын зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.5, 58.2.20, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны 2021 оны 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Зөгийн үүр" арга хэмжээний хүрээнд орон нутгийн анхан шатны эмч мэргэжилтнийг нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулахад шаардагдах 3,424,000 (гурван сая дөрвөн зуун хорин дөрвөн мянга)-н төгрөгийг зарцуулсугай.

2. Сургалтын зардлын тооцоог хавсралтаар баталсугай.


3. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012661



СУРГАЛТЫН ЗАГДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Өдөр, цаг, давтамж	Нийт дүн
Монголын эх баригчдын нийгэмлэгийн сургагч багш нарын зардал					
1	Багшийн цагийн хөлс	4	20,000	8 цаг	640,000
2	Сургагч багш нарын байрны зардал	4	75,000	2 өдөр, 2 өрөө	600,000
3	Сургагч багш нарын замын зардал	4	25,000	2 удаа /2 талдаа/	200,000
4	Сургалтын хоолны зардал	40 хүн	15,000	1 удаа	600,000
5	Гэрчилгээ хэвлүүлэх зардал	35	2,000	1 удаа	70,000
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн сургагч багшийн зардал					
6	Томилолт	1	33,000	4 хоног	132,000
7	Шатахууны зардал	130 л	2,200	2 удаа буюу ирж очих	572,000
8	Байрны зардал	1	70,000	3	210,000
9	Багшийн цагийн хөлс	1	50,000	8 цаг	400,000
10	Нийт үнэ				3,424,000